| 4.1.1.1 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна. | -ЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон тул албаны даргын 2024 оны Б/26 дугаар тушаалаар төрийн захиргааны 185 албан хаагчийн, Б/27 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний 39 албан хаагчийн, Б/43 дугаар тушаалаар нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд ажиллаж байгаа 10 албан хаагчийн цалин, нэмэгдлийг тус тус шинэчлэн батлуулсан.<br>-Төрийн албаны зөвлөлийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлд 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01-01/1052 дугаар албан бичгээр 22 албан хаагчид төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг шинээр, 56 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан нийт 78 төрийн захиргааны албан хаачид зэрэг дэв олгох саналыг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01-01/1052 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу тангараг өргөх болзол хангасан 3 албан хаагч тангараг өргүүлэх саналыг 2025 оны 02 дугаар сарын 26-ны 01-01/1053 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>-Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд 14 хот, 3 дагуул хот, 2 улсын зэрэглэлтэй хот байгуулах ажлын хэсгийн үүрэг даалгаврын дагуу байгууллагын шинэ бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэл, цалингийн мэдээллийг хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолоор “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журмыг дагуу Газар чөлөөлөх хэлтсийн бүтэц, орон тооны саналыг нийслэлийн Засаг даргын зөвлөлд 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр танилцуулан ГЗБГЗЗЕГ-т санал хүргүүлсний дагуу ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны Б/56 дугаар тушаалаар албаны бүтэц, орог шинэчлэн батлуулсан.<br>-ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны Б/56 дугаар тушаалаар албаны бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталсантай холбогдуулан нийт 72 албан хаагчтай сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлж, албаны даргын 2025 оны Б/188 дугаар тушаалаар албан хаагчдыг албан тушаалаас чөлөөлж, албаны даргын 2025 оны Б/202 дугаар тушаалаар 224 албан хаагчийг албан тушаалд томилсон. | |
| 4.1.1.2 | "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д нийцүүлэн салбарын албан хаагчдын “Албан тушаалын тодорхойлолт” боловсруулах батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Албан тушаалын тодорхойлолтын тоо | 21 аймгийн ГХБХБГ-ын улсын (ахлах) байцаагчийн 5 албан тушаалын тодорхойлолт, НГЗБА-ны 4 албан тушаалын тодорхойлолт, агентлагийн 19 албан тушаалын тодорхойлолтыг шинээр, агентлагийн 29 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулсан. | Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд “Албан тушаалын тодорхойлолт”-ыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.<br>Хянаж зөвшөөрөгдсөн албан тушаалын тодорхойлолтыг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/316 дугаар тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу шинээр бий болсон 5 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан хянуулж, ТАЗ-ын ГЗБГЗЗЕГ-ын дэргэдэх салбар зөвлөлд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01-01/184 дүгээр албан бичгээр хүргүүлж, салбар зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн. Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 7 дугаар хуралдаанаар төрийн захиргааны зарим удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг батлах тухай асуудлыг хэлэлцүүлж, батлах зөвшөөрлийг Төрийн албан зөвлөлөөс олгосны дагуу албаны даргын 2025 оны Б/38 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан.<br>Албаны бүтэц, орон тоо шинэчлэн баталсантай холбогдуулан төрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний 16 ажлын байрын тодорхойлолтыг боловсруулан албаны даргын 2025 оны Б/55 дугаар тушаалаар батлуулсан. | |
| 4.1.1.3 | Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сул болон эзгүй орон тоо | - | - Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна<br>- Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна. | Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зарыг байршуулж, төрийн захиргааны албан тушаалын 7 сул орон тооны захиалгыг зарлуулахаар ТАЗ-ийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлд 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01-01/1264 дүгээр албан бичиг хүргүүлсэн.<br>Салбар зөвлөлөөс тусгай шалгалтыг зохион байгуулж, нэр дэвшсэн 6 албан хаагчийг албан тушаалд томилж, ГЗБГЗЗЕГ-т 2025 оны 01-01/3333 дугаар томилсон тухай албан бичгийг хүргүүлсэн. | 100 |
| 4.1.1.4 | "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо" цахим системд мэдээллийг | Үйл ажиллагаа | Албан хаагчийн тоо | 245 | - "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо" цахим системд | Шинээр болон шилжин, сэлгэн томилогдсон, чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн, цалин, нэмэгдэл шинэчлэн баталсан, бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан 262 албан хаагчийн мэдээллийг давхардсан тоогоор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулах, тухай бүр шинэчлэх | | | | мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилсэн байна. | 1350 гаруй нэмэлт өөрчлөлтийг "Хүний нөөцийн нэгдсэн систем"-д бүртгэсэн. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн удирдлагын системд бүтэц, орон тоо шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан 72 албан хаагчийн, шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн, шилжсэн, сэлгэн томилогдсон албан хаагчдыг мэдээллийг бүртгэн давхардсан тоогоор 580 гаруй өөрчлөлтийг хийж бүртгэсэн. | |
| 4.1.1.5 | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөсөн арга хэмжээний тоо | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" /2021-2024/-ыг баталсан. | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, албаны даргын 2025 оны Б/54 дүгээр тушаалаар батлуулсан. Батлагдсан хөтөлбөрийн дагуу Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.<br>-Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолын дагуу улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосны дагуу 10 гэрээт ажилтны хөлсийг 2025 оны Б/128 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>-Төрийн албаны тухай хууль, ЗГ-ын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу албаны даргын 2025 оны Б/113, Б/118 дугаар тушаалаар нийслэлийн алслагдсан Налайх дүүрэгт ажиллаж байгаа 2 төрийн захиргааны болон үйлчилгээний 20 албан хаагчид орон нутгийн нэмэгдлийн тус тус олгож шийдвэрлэлээ.<br>-Эрүүл мэндийн шалтгааны улмаас цалинтай чөлөө хүссэн 4 албан хаагчид цалинтай чөлөө, албан хаагчийн гэр бүлийн гишүүн нь эрүүл мэндийн шалтгааны улмаас асрахаар чөлөө хүссэн 8 албан хаагчид цалинтай чөлөө, ар гэрийн шалтгааны улмаас чөлөө хүссэн 7 албан хаагчид цалинтай болон цалингүй чөлөө, сургалтад хамрагдах 3 албан хаагчид | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цалинтай чөлөө тус тус олгож, 2 албан хаагчийн ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, 7 албан хаагчид жирэмсний болон амаржсаны амралт, 5 албан хаагчид хүүхэд асрах чөлөө олгож шийдвэрлэлээ.<br>-Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10.1.3 дахь заалтад заасны дагуу албан хаагчийн ахуй амьдрал, ар гэрт гачигдал тохиолдсон 7 албан хаагчид нийт 2,9 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 9 албан хаагчид албаны даргын тушаалаар цалинтай чөлөө олгож шийдвэрлэсэн.<br>-Өндөр насны тэтгэвэрт гарах насанд хүрсэн 1 албан хаагчид 36 сарын цалинтай тэнцэх буцалтгүй тусламж олгож шийдвэрлэсэн.<br>-Номун эмнэлэгтэй хамтран нийт 178 албан хаагчийг эмнэлгийн урьдчилан сэргийлэх 6 төрлийн үзлэгт, нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран эрт илрүүлгийн үзлэгт 20 албан хаагчийг Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвд тус тус хамруулсан. | |
| 4.1.1.6 | Салбарын хэмжээнд “Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Салбарын хэмжээнд Жэндерийн талаарх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. | Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Албаны “Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хорооноос Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол Цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээний “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” нэг сарын аянд Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба нэгдэж, 13 төрлийн мэдээллийн эх сурвалжаар нийт 67 удаагийн нийтлэл оруулж иргэд, албан хаагч, байгууллагуудад сурталчиллаа. Мөн аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн орчинд бусдын ялгаатай байдлыг буруушаах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, дарамтлах зэрэг үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хууль болон бусад ойлголтыг өгөх зорилгоор Багануур дүүргийн Гүн галуутай цогцолбор сургуулийн 5-7 ангийн сурагчдын дунд сургалт нөлөөллийн ажлыг Багануур дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулсан.<br>Жендрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хүрээнд тус албаны албан хаагчдын нас хүйсийн тэнцвэртэй байдлын судалгааг гаргаж, эрэгтэй, эмэгьэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах зорилгоор 2025 оны 01 дүгээр сард Номун эмнэлэгтэй хамтран 164 албан хаагчийг “Урьдчилан сэргийлэх үзлэг”-т хамруулсан.<br>Тус албанд нийт 229 албан хаагч ажиллаж байгаагийн 95 буюу 42% эрэгтэй, 134 буюу 58% эмэгтэй албан хаагч байна. | |
| 4.1.1.7 | Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх | Үйл ажиллагаа | Мэдээ, судалгааны тоо | - | Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын бүх төрлийн нэгдсэн судалгаа, мэдээллийг цуглуулж, нэгтгэн цаг хугацаанд нь ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны бүтэц, орон тооны судалгаа, төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлийн судалгаа, сул орон тооны судалгаа, хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрэх жендэр буюу нас, хүйсийн тэнцвэртэй байдлын судалгаа, орон нутагт ажиллаж байгаа албан хаагчийн ажилласан жилийн судалгаа, шилжин, сэлгэн ажилласан албан хаагчдын судалгаа, албан тушаалын тодорхойлолтын судалгаа, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчийн судалгаа, мэдээллийг тус тус ГЗБГЗЗЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн.. | 100 |
| 4.1.1.8 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг | Үйл ажиллагаа | Тайлангийн тоо | 2022 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын | Тус албаны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан.<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг дэмжих, албан хаагчдын ёс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, тайлагнах | | | | даргаар батлуулсан байна<br><br>Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна. | зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, харилцаа хандлагыг нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн байгууллагын соёлыг хэвшүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх байгууллагын үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, ёс зүйтэй хамт олон” аяныг зохион байгуулсан.<br>-АТГ-ын Мөрдөн шалгах хэлтээс ирүүлсэн 24 дүгээр мөрдөгчийн мэдэгдэл, 2025 оны 03/8874 дүгээр зөвлөмжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр, 05 дугаар сарын 26-ны өдрүүдэд холбогдох авлигын гэмт хэрэг гарах болсон шалтгаан, нөхцөлийг арилгуулах, ажилтан, албан тушаалтнуудыг ёс зүйн болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж чиглэлийг өгсөн.<br>- Албаны 225 албан хаагч “Авлига, ашиг сонирлын зөрчилгүй, ёс зүйтэй ажиллах баталгаа”-нд гарын үсэг зурж баталгаажуулсан.<br>-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.” гэж заасны дагуу 68 төрлийн мэдээллээс тус албаны чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг агуулсан мэдээллийн сан үүсгэж, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулж нийтлэх, нээлттэй мэдээлэл, цахим хуудсыг шинэчлэх, цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавихад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдох нэгж, албан хаагчийг хариуцуулан, мэдээлэл байршуулах хугацааг заасан хуваарийг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлуулж, байгууллагын цахим хуудас болон shilen.gov.mn-д тогтмол хугацаанд нь байршуулан улирал тутам мэдээллийг НЗДТГ-т хүргүүлэн ажилласан.<br>-Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албатай хамтран зохион байгуулсан Залилах гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх нь сэдвээр 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан.<br>-2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 01 дүгээр сарын 15-ны өдрүүдэд нийслэл болон 9 дүүргийн 11 Газар зохион байгуулалтын албаны нийт 198 албан хаагчдад албан тушаалаа хэрэгжүүлэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулийн хориглолт хязгаарлалтыг зөрчихгүй байхад анхаарч ажиллах хүрээнд "2024 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргах тухай", "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт", "Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар гаргах", Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг тус тус зохион байгуулсан. | |
| 4.1.1.9 | Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч бүртгэх. | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Ашиг сонирхлын зөрчилтэй гэх нөхцөл байдал үүссэн 4 албан хаагч мэдэгдэл, тайлбарыг эрх бүхий албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлсэн. | 100 |
| 4.1.1.10 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 126 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлэн хянуулж, албан хаагчдыг томилсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. | | |
| **4.2.6** | **Тогтоол шийдвэрийн, биелэлтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлсөн байдал** | **78 тогтоол шийдвэрийн биелэлтийг журамд заасан хугацаанд тайлагнасан.** | **Бүртгэлд авсан тогтоол шийдвэрийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд холбогдох газарт тайлагнасан байна.** | | |
| 4.2.6.1 | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗЕГ болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | - | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэлжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох газарт тайлагнасан байна. | Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол, НЗД-ын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу бодлогын баримт бичгийн байгууллагад хамаарах заалтуудын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хүргүүлэн ажилласан.<br><br>-Засгийн газрын 2 тогтоолын 2 заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай байгуулсан гэрээнд тус албаны хариуцах хэрэгжүүлэх 11 арга хэмжээ, НИТХ-ийн 4 тогтоол, шийдвэрийн 4 заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд 2025 оны биелэлтийн дундаж 83,5 хувьтайгаар тайлагнан ажилласан.<br><br>-ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны 2 тушаал, 1 албан даалгавар ирснийг хяналтад авч, хэрэгжилтийг тухай бүр хүргүүлж ажилласан. | 100 |
| **4.2.7** | **Байгууллагын хэмжээнд эрх зүйн баримт бичиг боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **380 тушаал, 280 гэрээ, 1 журам, 1 эмхэтгэл** | **-** | **Тушаал болон гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгож бүртгэсэн байна. Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт орж батлагдсан** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **байна. Эмхэтгэл бэлэн болсон байна.** | | |
| 4.2.7.1 | Албаны даргын тушаалын үндэслэлийг хянаж, бүртгэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тушаалын төслийн тоо | 2024 онд 551 тушаал гарч албажсан байна | Албаны даргын тушаалын төслийг боловсруулж, бүртгэл хөтөлж, тушаалын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, хэрэгжилтийн тайланг гаргасан байна. | Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр А тушаал 70, хүний нөөцийн чиглэлээр Б тушаал 212 буюу нийт 282 тушаалд холбогдох нэгжүүдээс санал авч, хууль зүйн үндэслэлийг хянаж, баталгаажуулсан. | 100 |
| 4.2.7.2 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, албажуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шинэчлэн боловсруулсан дүрэм, журмын тоо | - | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. | Албаны бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан албаны Архив, албан хэрэг хөтлөлтийн журам, Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж байна. | 50 |
| **4.2.8** | **Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан загвар, аргачлал** | **Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор журам шинэчлэн батлагдсан.** | **Журманд заасан хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна.** | | |
| 4.2.8.1 | Байгууллагын болон зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж, тайлагнах | Үйл ажиллагаа | 14 төлөвлөгөө, 28 тайлан | 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн тайланг БХБЯ-нд хүргүүлж дүгнүүлсэн. Зохион байгуулалтын 13 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, улирал бүрийн 46 тайланг гарган | Байгууллагын болон Зохион байгуулалтын нэгжийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна. Байгууллагын төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд нийт 4 бүлэг, 43 зорилт, 90 арга хэмжээг тусган санал авч нэгтгэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргатай 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан.<br><br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хуулийн хугацаанд хүргүүлэхээр ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүгнэж, архивласан. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр гарган дүгнүүлсэн байна. | | |
| 4.2.8.3 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Нийт албан хаагчдын төлөвлөгөө, тайлан | 2024 онд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр, гүйцэтгэлийн тайланг улирал бүр гарган үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан. | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны 130 албан хаагч, дүүргийн газар зохион байгуулалтын албаны 95 албан хаагч, шилжин, сэлгэн, шинээр томилогдсон 78 албан хаагч буюу давхардсан тоогоор нийт 303 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хanган ажиллаж байна.<br>Албаны даргын 2024 оны А/149 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний багаар хэлэлцүүлэн дүгнэж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээний дагуу 1 дүгээр улиралд 210 албан хаагчдад 149,023,750 сая төгрөгийн урамшуулал олгосон.<br>Үнэлгээний багийг 2025 оны А/66 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, 2025 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх ажлыг зохион байгуулж байна. | 100 |
| 4.2.8.5 | Дүүргийн Газар зохион байгуулалтын албадын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөний хэрэгжилт | - | Дүүргийн Газар зохион байгуулалтын албадын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.<br>Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг хурлаар хэлэлцүүлж, | Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх 2025 оны төлөвлөгөөнд төлөвлөгөөт болон, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын чиглэлээр 6, байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг сайжруулах, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах чиглэлээр 7, дотоод ажлын чиглэлээр 5 арга хэмжээ буюу нийт 18 арга хэмжээг тусгаж батлуулсан бөгөөд хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.<br>Дотоод хяналтын явцад албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангаагүй, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | биелүүлээгүй буюу албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, албан бичиг, өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн, шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргасан, ажлын цагийг хангалтгүй ашигласан нийт 12 албан хаагчид Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн дагуу сонсох ажиллагаа явуулж, 6 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1-48.1.3 дахь заалтад заасан сахилгын шийтгэл ногдуулсан бөгөөд 1 албан хаагчид “төрийн албанаас халах” сахилгын шийтгэл ногдуулсан.<br><br>Мөн иргэд олон нийтийн зүгээс ирж буй өргөдөл, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр зөвлөмж, чиглэл боловсруулан албаны даргын 2025 оны 01-01/348, 01-01/1820, 01-01/2020, 01-01/2094 дүгээр албан бичгээр тус тус холбогдох нэгжүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br><br>Төлөвлөгөөний дагуу албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг хэмжих, цаг ашиглалтыг хянах, ажлын байрны давхцал болон хийдлийг илрүүлэх, албан тушаалын тодорхойлолтонд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж буй эсэхийг тодорхойлох зорилгоор албан тушаалын шинжилгээ хийх ажлын удирдамжийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулж, удирдамжийн дагуу Баянгол болон Баянзүрх дүүргийн Газар зохион байгуулалтын албадад тус бүр ажлын 5 өдөр ажиллаж, дүгнэлтийг танилцуулсан. | |
| **4.2.10** | **Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын** | **Үйл ажиллагаа** | **Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь** | **Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төри** | **Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | | | **йн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр батлагдсан.** | | | |
| 4.2.10.1 | Батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо | - | “Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө“-г боловсруулан Албаны даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан албаны даргаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 26 төрлийн сургалтад давхардсан тоогоор 1479 албан хаагчийг сургалтад хамруулсан.<br>Төрийн албан хаагчдыг чадавхижуулах үйл ажиллагааны хүрээнд Удирдлагын академиас зохион байгуулдаг эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад 5, богино хугацааны сургалтад 8 албан хаагчийг тус тус хамруулсан бөгөөд нийт 18 албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад харуулсан. | 100 |
| 4.2.10.2 | Салбарын хууль тогооомжийн хүрээнд албан хаагчдад мэргэжил арга зүгээр хангаж, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар болон салбарын хууль тогооомжийн хүрээнд байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүгээр хангаж ажилласан байна. | Төрийн албан хаагчдыг чадавхижуулах үйл ажиллагааны хүрээнд Удирдлагын академиас зохион байгуулдаг эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад 5, богино хугацааны сургалтад 8 албан хаагчийг тус тус хамруулсан бөгөөд нийт 18 албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад харуулсан. | 100 |
| **4.2.12** | **Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх** | **Үйл ажиллагаа** | **-** | **-** | **Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна.** | | |
| 4.2.12.1 | Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан | Салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ | Салбарын үйл ажиллагаатай холбоотой | Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны ажлын байр болон нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 3 төвд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арга хэмжээний тоо | мэдээллийг мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчилсан. | үйлчилгээг орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулж, нийтэд хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | нийт 22 цахим үйлчилгээний киоск төхөөрөмжийг байршуулан, тэдгээрээр дамжуулан газрын харилцааны үйлчилгээг сурталчлах ажлыг үзүүлж байна. Мөн киоск төхөөрөмжөөс хэрхэн үйлчилгээ авах талаар гарын авлагыг шинэчлэн боловсруулж байршуулсан.<br><br>Албаны үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилахаар:<br><br>-байгууллагын цахим хуудсанд видео мэдээ 8, 30 гаруй төрлийн постер, албаны youtube хуудсанд 9 видео мэдээг тус тус байршуулсан. Мөн холбогдох нэгжийн дарга нар Eagle, NTV, MNB, Тэнгэр телевиз, TV5 телевизийн Live сувгуудад давхардсан тоогоор 10 гаруй удаа ярилцлага өгсөн.<br><br>2025 онд тус алба үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан нийслэлийн Боловсролын газартай хамтран нийслэлийн 125 ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Эх дэлхий-Бидний гэр” газарзүйн олимпиадыг зохион байгуулж, албаны үйл ажиллагааг сурталчилан ажилласан.<br><br>Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд албаны үйл ажиллагааг танилцуулах, үйлчилгээ авах боломжийг бий болгох ажлын хүрээнд нийт 5 видео контентод дүрсний орчуулга хийлгэж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран ажилласан. | |
| **4.2.13** | **Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа ны зардал** | **Баримт бичиг** | **2023 онд 3600 албан бичиг, 500 өргөдөл, гомдол хүлээн авсан.** | **Газарт ирсэн, явсан, өргөдөл гомдолыг “Байгууллагын удирдлагын цогц цахим систем”-д бүртгэлжүүлж,** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **тайлан мэдээг гаргасан байна.** | | |
| 4.2.13.1 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж, тайлагнах | Үйл ажиллагаа | Ирүүлсэн албан бичгийн тоо, Явуулсан албан бичгийн тоо, Өргөдлийн тоо, Тайлангийн тоо | 2024 онд 8643 албан бичиг, 2244 өргөдөл, гомдол хүлээн авч, хариутай 8383 албан бичиг, 2137 өргөдөл, гомдол шийдвэрлэсэн. | - Байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.<br>-Байгууллагаас явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.<br>- Хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна.<br>- Өргөдөл, гомдлын мэдээг холбогдох байгууллагад улирал бүр тайлагнасан байна. | Нийслэл, дүүргийн ГЗБА-ны хэмжээнд 13392 албан бичиг ирснээс 12892 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, судалж байгаа 500 албан бичиг байгаа бөгөөд хугацаа хэтрэлт үүсгээгүй, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 2 цаг байна.<br><br>Тоон гарын үсгээр нийт 8722 албан бичгийг баталгаажуулан, холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хүргүүлсэн.<br><br>Албаны хэмжээнд 3174 өргөдөл, гомдол ирснээс 2933 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, судалж байгаа 241 өргөдөл гомдол байна.<br>Шийдвэрлэлтийн явцад хугацаа хэтрэлт үүсгээгүй, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 23 цаг 25 минут, шийдвэрлэлтийн индекс 92.1% буюу А үнэлгээтэй байна.<br><br>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг ГЗБГЗЗЕГ-т 23 удаа цахим шуудангаар хүргүүлсэн. | 92,1 |
| **4.2.14** | **Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хадгаламжийн нэгж** | **Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 онд 358 хадгаламжийн нэгж үүсгэсэн.** | **Байгууллагын архивт баримт хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, хадгалах, хамгаалах, ашиглуулах, данс бүртгэл хөтлөх, устгах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.14.1 | Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах | Үйл ажиллагаа | Хадгаламжийн нэгжийн тоо | 2024 онд Байгууллагын хөтөлж дууссан баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивласан. | 2024 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх хуваарь гарган батлуулсан байна. 2024 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” болон нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивласан байна. | Архивын ажлын төлөвлөгөөнд 13 арга хэмжээ тусган боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр батлуулсан.<br><br>Архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 109582 хадгаламжийн нэгж болон 2024 оны нийт 2372 хадгаламжийн нэгжийн 457673 хуудас баримтын данс бүртгэл үүсгэн хүлээн авч бүртгэлжүүлсэн. | 100 |
| 4.2.14.2 | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын архивын чиг үүргийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | Эхний хагас жилд:<br><br>Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангасан байна.<br><br>Жилийн эцэст:<br><br>Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлсэн байна. | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сард батлуулан, төлөвлөгөөний дагуу архивын өрөөний засвар үйлчилгээг 3,900,000, нягтруулсан шүүгээ 78 ширхэгийг 93,000,000, хадгаламжийн нэгжийн хамгаалалалтын хайрцагийг 29,388,000 төгрөгөөр тус тус худалдан авсан.<br><br>2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дүүргийн Газар зохион байгуулалтын албадын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| **4.4.3** | **Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх** | **-** | **Санхүүгийн хяналт шалгалтын дүн** | **Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил** | **Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **тод тайлагнаж ажилладаг.** | | | |
| 4.4.3.1 | Төсвийн зардлыг бууруулж, хэмнэлт гаргаж ажиллах, бараа материалын болон үйлчилгээний орлогод хяналт тавьж орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.<br>Орлогын төлөвлөгөөг биелүүлж санхүү төсвийн зөрчилгүй ажилласан байна. | 2025 оны эхний 5 дугаар сарын байдлаар улсын төсвийн санхүүжилт 3,320,906.600, орон нутгийн газрын хянан баталгааны санхүүжилт 667,335,430 төгрөгийг тус тус хүлээн авсан.<br>2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3,376,877,576 төгрөгийн урсгал зардлын, 596,795,478 төгрөгийн газрын хянан баталгааны зардлын зарлагын гүйлгээ тус тус хийгдсэн. Мөн НЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст харилцах дансны нэр данс зөрүү орлогын гүйлгээ болон санхүүжилтын орлого татуулах хүсэлтийг тухай бүрт гарган өгч гүйлгээ хийх эрхээ нээлгэж ажиллалаа.<br><br>2025 онд 200,0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг батлуулснаас 2025 оны 05 сарын байдлаар 91,3 сая төгрөгийн барьцаа бүртгэл, кадастрын зураг, архивын лавлагаа болон бусад үндсэн үйл ажиллагааны орлого орсон.<br>МУ-ын Засгийн газрын 2024 оны 173 дугаар тогтоолоор үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоосон бөгөөд тогтоолын дагуу дүүргийн газар зохион байгуулалтын албадад уг тогтоолыг 2025 оны 01-02/1202 дугаар албан бичиг хүргүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 100 |
| 4.4.3.2 | Байгууллагын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж, аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | Албаны 2024 оны санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж, “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт авсан.<br>Мөн Нийслэл дэх Дотоод аудитын газраас Монгол Улсын Сангийн сайдын баталсан 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн СХШХ/06 дугаар нэгдсэн удирдамжийн дагуу албаны 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдэж, холбогдох тайлан мэдээ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгааг цаг тухай бүрт нь гарган өгч ажилласан.<br><br>Албаны санхүүгийн хагас жилийн тайланг хуулийн хугацаанд e-report.mof.gov.mn цахим системээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнаж ажиллана. | |
| 4.4.3.3 | Өр авлагыг цаг тухайд нь барагдуулж, өмнөх оныхоос бууруулж ажиллах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үүссэн өр, авлагыг цаг тухайд нь барагдуулж тайлант жилд өр, авлагыг бууруулан ажилласан байна. | Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, албан хаагчийн цалин хөлсийг цаг тухайд нь олгох, харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт, үйлчилгээний төлбөр тооцоог цаг тухайд нь хийж өр, авлага үүсгэхгүй ажилласан.<br><br>2025 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулан, зардлын гүйцэтгэлд хяналт тавьж, өр авлагагүй ажилласан. | 100 |
| 4.4.3.4 | Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үндсэн хөрөнгийн болон бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажилласан байна. | Санхүүгийн анхан шатны баримт материалын дагуу 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 140,174,809 төгрөгийн орлого авч үүнээс 101,583,334.14 төгрөгийн бичиг хэрэг, 6,057,400 төгрөгийн аж ахуйн материал, 6,173,340 төгрөгийн шатахуун шаардах хуудсын дагуу зардлыг анхан шатны баримт материалын дагуу хөтөлж тайлагнасан.<br><br>Албаны даргын 2025 оны А/73 дугаар тушаалаар тооллогын комиссийг шинэчлэн байгуулж, тооллогыг 6 дугаар сарын 12-ны өдрөөс 25-ны өдрийн дотор хийхээр төлөвлөсөн ба үр дүнг 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулна. | 100 |
| 4.4.3.6 | Санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайлан, Шилэн дансанд оруулах мэдээллийг хууль журамд заасан | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн | Хуульд заасан хугацаанд мэдээ тайланг тайлагнаж ажилласан байна. Мэдээ тайлангийн | 2025 оны эхний 5 сарын байдлаар НДШ-ийн тайлан-5, ХХОАТ-ын тайлан 2-ийг харьяа дүүргийн татвар, нийгмийн даатгалын байгууллагад, ГЗБГЗЗЕГ-т 5 сарын мэдээ, тайланг хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацаанд оруулж мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлсэн байна. | | | төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | хугацааг хоцроохгүй байх. | Шилэн дансны 29 бүлгийн мэдээг сар бүр мэдээлж, ил тод болгосон.<br>Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт албаны худалдан авах ажиллагааны тайланг тухай бүрт нь тайлагнаж ажилласан. Мөн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд газар чөлөөлөх нөхөх олговрын зардалд 2025 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 45,6 тэрбум төгрөгийг олгосон. | |
| 4.4.1.5 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | Үйл ажиллагаа | Засгийн газрын 2014 оны 384 дугаар тогтоолын дагуу Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал | Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын дагуу Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын 2024 оны холбогдох мэдээ, тайланг хуулийн хугацаанд мэдээлсэн. | - Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбар сар, улирал, бүтэн жилээр мэдээлсэн байна.<br>- Тухайн жилийн төсөвт нэмэлт өөрчлөлт орсон тухай мэдээллийг оруулсан байна.<br>- 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шилэн дансанд мэдээлсэн байна.<br>- 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансанд мэдээлсэн байна.<br>- 2024 оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд | 2025 оны эхний 05 дугаар сарын байдлаар албаны шилэн дансанд 29 бүлгийн 73 мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарцуулсан жилийн тайланг шилэн дансанд мэдээлсэн байна.<br>- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг шилэн дансанд мэдээлсэн байна.<br>- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хамт шилэн дансанд мэдээлсэн байна.<br>- Хандив тусламжийн хэмжээ түүний зарцуулалтын жилийн тайланг шилэн дансанд мэдээлсэн байна. | | |
| **4.4.4** | **“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Салбарын хэмжээнд 4761 мод** | **2024 онд ГЗБГЗЗГ, Нийслэлийн ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ нийт 2276 мод тарьсан.** | **“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, салбарын хэмжээнд тайланг нэгтгэн гаргасан байна.** | | |
| 4.4.4.1 | “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих | Үйл ажиллагаа | Өмнөх жилд тарьсан модны тоо | 2024 онд тус салбарын хэмжээнд хавар нийт *** мод тарьсан нь хэвийн | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион | Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны 121 албан хаагч 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Тарвагатайн аманд байрлах “Инчон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ургаж байна. Тарьсан модыг тогтмол арчлах ажлыг газрууд зохион байгуулан ажиллаж байна. | байгуулж, тайланг салбарын хэмжээнд нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | мөрөөдлийн төгөл”-д 1200 ш шинэс модны суулгац тарьсан. | |
| Нийт 4 бүлэг, 43 зорилт, 90 арга хэмжээг тусгаж, 91,2 хувийн хэрэгжилттэй байна. | | | | | | | |

---oOo---